

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын тэмдэглэл

Хурлын нэр: Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурал

Огноо: 2026 оны 04 дүгээр сарын 23

Цаг: 14:00

Байршил: "Дорнод худалдаа" ХК-ийн байр

Хурал даргалагч: Д.Тунгалагтуул

Тэмдэглэл хөтлөгч: Б.Батцэцэг

1. Хуралд оролцсон гишүүд:

- Д.Тунгалагтуул
- Д.Шинэбаяр
- Ш.Билгүүн
- Ш.Нямдулам
- Д.Эрдэнэболд

Ирц: 9 гишүүнээс 5 нь оролцсон (55.56%)

2. Хэлэлцэх асуудлууд

1. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт хэлэлцэх
2. 2026–2027 оны бизнес төлөвлөгөө, чиглэлийг хэлэлцэж батлах
3. Ноогдол ашиг хуваарилах эсэх
4. Бусад / ТУЗ-ийн дарга болон гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах

3. Хэлэлцсэн асуудал, гаргасан шийдвэр

Асуудал 1: Санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт

Товч тайлбар: 2025–2026 онд 12×24 хэмжээтэй, В1 давхартай 5 давхар барилга барьж улсын комисст хүлээлгэн өгсөн. Санхүүгийн аудитын дүгнэлттэй танилцав.

Шийдвэр:

- Жаргалангийн сууринд баригдах барилгын ажлыг 2026 оны 12 сар хүртэл гүйцэтгэхэд зориулж Голомт банкнаас 1 тэрбум төгрөгийн зээл шийдвэрлүүлэх.
- 2026 оны 05–06 саруудад дээврийн урсгал засварын ажлыг дуусгах.

Асуудал 2: Бизнес төлөвлөгөө

Товч тайлбар: 2026–2027 оны зорилтуудыг хэлэлцэв.

Шийдвэр:

- Гадаа худалдаа эрхлэгчдийг тэгш тоогоор павилонд хуваарилж, одоогийн талбайг чөлөөлөх.
- Байгууллагын ногоон байгууламж болон ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн төлөвлөх.
- Байгууллагын санхүүгийн тогтвортой, өсөлттэй байдлыг хангах
- Шинэ объектын бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх
- Урсгал засваруудыг тогтмолжуулах, шинээр төлөвлөх
- Байгууллагын хүний нөөцийн бодлогыг сайжруулан ажлын байрны тогтвортой байдал болон хүний нөөцийн бодлогын хөгжлийг хангах

Асуудал 3: Ноогдол ашиг

Товч тайлбар: Бүтээн байгуулалтын ажлууд болон бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлагыг харгалзан ноогдол ашиг хуваарилахгүй байх санал гаргав.

Шийдвэр: Ноогдол ашиг хуваарилахгүй байх тухай санал 100% дэмжигдэв.

Асуудал 4: ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт

Товч тайлбар: Оролцоо хангалтгүй гишүүдийг хасч, шинэ гишүүд томилох санал гаргав.

Шийдвэр:

- ТУЗ-ийн даргаар Д.Тунгалагтуул сонгогдов.
- Содхүү, Шинэбадам нарыг гишүүнээс хасч, Н.Энхболд, Н.Пүрэвэ нарыг хараат бус гишүүнээр томилов.

4. Дараагийн хурал

Огноо, цаг: 17:00.

Байршил: Дорнод аймаг, Хэрлэн сум, 6-р баг, Шүр зах оффисын байр, 204 тоот

5. Хурал хаасан цаг 17:00

Тэмдэглэл хөтлөгчийн гарын үсэг:

Хурал даргалагчийн гарын үсэг:



—oOo—

